



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2022 оны
01-р сар

Нийгмийн даатгалын санд 2022 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар нийт 109.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 108.38 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 203845 иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 99.4 тэрбум төгрөг зарцуулжээ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд энэ оны 01 дүгээр сард 109.3 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 71.7% буюу 87.7 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 6.2% буюу 7.6 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 4.8% буюу 5.9 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1.9% буюу 2.3 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 15.2% буюу 18.6 тэрбум төгрөг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА


2022 оны 01 дүгээр сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 99.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 2.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сан


Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 94.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 190550 иргэдийн тэтгэвэрт 88.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 74.9 хувь буюу 70.6 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 146686 иргэнд зарцуулсан байна.

Тэтгэмжийн даатгалын сан


Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Энэ оны 01 дүгээр сард тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 9978 иргэнд 6.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт тэтгэмжид зарцуулсан хөрөнгийн 4.3 тэрбум төгрөг буюу 60.6 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмж эзэлж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 01 дүгээр сард тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 2014 иргэнд 1.1 тэрбум төгрөгийг зарцуулав.

Ажилгүйдлийн даатгалын сан


Ажилгүйдлийн даатгалын санд 01 дүгээр сард 1.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 1382 хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 3.8 тэрбум төгрөгийг зарцуулсан. Сангийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 212.5 сая төгрөгөөр буурч, зарлага 915.8 сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

01 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 258.97 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 97.8 хувь буюу 253.3 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Мөн авлагын 52.6 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал


Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /сая төг, өссөн дүнгээр/

	2021_01 сар	2022_01 сар	Зөрүү
Тахир дутуугийн	946.4	910.9	-35.5
Тэжээгчээ алдсаны	97.7	115.5	17.8
Тэтгэмж. төлбөрийн	52.3	27.3	-25.0
Сувиллын	3.0	1.6	-1.4
Нийт дүн	1 096.7	1 055.3	-41.4

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага /сая төгрөгөөр/



Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 1 дүгээр сарын байдлаар нийт 760.5 сая төгрөг төлөвлөснөөс 555.3 сая төгрөг зарцуулж, 205.2 сая төгрөг хэмнэсэн байна. Батлагдсан орон тоо 433 байгаагаас 442 орон тоогоор нийт 9 орон тоогоор илүү ажилласан.

	2021_1 сар	2022_1 сар	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Цалингийн сан. нийгмийн даатгалын шимтгэл	458.9	474.7	-15.8	3.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	176.9	80.6	96.3	54.4%
Дүн	635.8	555.3	80.5	12.6%